



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/580

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 5.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган суманд зохион байгуулагдаж буй Жангар II наадмын арга хэмжээнд тоглох “Жангар” дуулалт жүжгийн уран бүтээлчид, хэрэглэгдэхүүнийг тээвэрлэх шатахууны зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулах 1 465 500 төгрөг /Нэг сая дөрвөн зуун жаран таван мянга таван зуун/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалт”-ын 5.7 дахь “Гурван сэнхэр төвтэй-Таван од аялал жуулчлал” дэд хөтөлбөрөөс гаргахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Зах А/580 СБ
02 02998

Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр
сарын 12-ны өдрийн А/580 дугаар
захирамжийн хавсралт



ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Тээврийн хэрэгсэл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1	Тоёота Hiace 1009 ХОУ (2 талдаа 800 км*18л/100км)	л	144	2090	300.9
2	Hyundai Country 3325 ХОА (2 талдаа 800 км*20л/100км)	л	160	2510	401.6
3	Hyundai Migthy 3573 ХОУ (2 талдаа 800 км*20л/100км)	л	144	2510	361.4
4	Тоёота ланд круйзер 200 0001ХОА (200 талдаа 800км*20л/100)	л	160	2510	401.6
	ДҮН				1 465.5

-oOo-